

БАРУУН МУХДАГИЙН ХҮННҮ БУЛШ

С.БАТ-ЭРДЭНЭ

ШУТИС, БУХС, e-mail: tlbaagii@yahoo.com

ТҮЛХҮҮР ҮГ: Хүннү, булш, Баруун мухдаг, хүүхдийн оршуулга, үүдэвч

ТОВЧ АГУУЛГА: Энэхүү өгүүлэлд Булган аймгийн нутгаас шинээр илрүүлэн олсон Хүннүгийн оршуулгын газрын тухай танилцуулж байна. Тус оршуулгын цогцолбор газарт хүннүгийн үеийн жирийн иргэдийн болон язгууртны булш нэгэн доор орших ба язгууртны гэмээр үүдэвч бүхий том булшнууд нь цагариг хэлбэртэй байгаа нь төдийлөн түгээмэл тохиолддоггүй юм. Уг оршуулгын газарт малтан судалсан таван булшны нэгд хүүхдийг вааранд хийж оршуулсан байсан нь анхаарал татаж байна.

Монгол нутагт эртнээс нааш амьдарч байсан овог аймаг, улс үндэстэн бүр тухайн үеийнхээ Евроазийн болон Дорнод Европын ард түмний түүх, угсаа соёлын үйл явцад тодорхой хэмжээгээр нөлөөлж байсан ба түүгээр барахгүй түүхэн хөгжингүй үеүдэд улс төрийн ноёрхогч хүчин байж нүүдлийн аж ахуйг хэлбэршүүлэн тогтоож, уламжлал болгон хадгалсаар ирсэн юм. Тэгвэл эдгээр нүүдэлчин овог аймгуудыг хөдөлгөөнд оруулж, Төв Азид анхны төрт улс байгуулсан нь Хүннүчүүд юм.

Хүннүгийн оршуулгын дурсгалт газар Монгол улсын Дорноговь болон Баян-Өлгий аймгаас бусад бүх аймгийн нутагт, ОХУ-ын Буриадын нутаг Өвөр Байгалаас, БНХАУ-ын Өвөр Монгол ба түүнтэй хил залгаа бүс нутгаас илэрч олджээ (Ерөөл-Эрдэнэ 2010: 10-18). Монгол нутгаас 2004 оны байдлаар 70 гаруй газарт 5000 орчим Хүннү булш бүртгэгдээд байгаа бөгөөд 420 орчмыг нь малтан судалсан мэдээ байна (Төрбат нар 2004: 186-196). Эдгээрээс Хүннүгийн язгууртны оршуулгын дурсгалт газар Монгол орны Төв аймгийн Ноён уул, Сэлбийн Бэлхийн ам, Архангай аймагт Гол мод – I, II буюу Балгасан тал, Хэнтий аймагт Дуурлиг нарс, Бор булаг, Ховд аймагт

Тахилтын хотгор буюу Хаалгатын завсар зэрэг долоон газраас, ОХУ-ын Буриадын Ильмийн ам, Царам, Тувагийн Бай-даг II зэрэг газарт олдож судлагджээ. БНХАУ-ын нутагт 1970 оноос хойш Хүннүчүүдэд холбогдох дурсгалыг судлах болсон байна. Тэр үед Тоухунбаола (Тоорийн улаан балгас), Алучайден (Ар Цайдам), Ёлонтай, Сигоупань, Мацингоу, Баодунгоу (Бодон гуу) зэрэг дурсгалт газрууд ӨМӨЗО-ны Ордос болон баруун өмнө талын нутгуудаас дараалан нээгдэж судлагджээ (Ерөөл-Эрдэнэ 2010: 10-18).


Энэхүү өгүүлэлд дурдаж буй Хүннүгийн оршуулгын газрыг археологич З.Батсайханы удирдсан “Баруун Монгол: Археологи, антропологи” төслийн хүрээнд МУИС-ийн Археологи-Антропологийн тэнхмийн хайгуул судалгааны багийнхан 2006 онд нутгийн ард иргэдийн мэдээллээр олж илрүүлсэн билээ. Уг дурсгалт газар нь Булган аймгийн Могод сумын нутагт сумын төвөөс баруун хойш 60 гаруй км, Сайхан сумаас зүүн урагш 20 гаруй км зайд Баруун Мухдаг хэмээх газар оршино. Баруун Мухдаг нь Орхон голын их хавцлын эх болон Асгат хэмээх жижиг гол хоёрын дунд, уулсаар хүрээлэгдэн орших нэлээн аглаг

газар бөгөөд уг дурсгал хоёр талаараа гүн хэрчигдсэн ангал хавцалын хоорондох өндөр дэвцэг дээр оршино (Зураг 1).



Зураг 1. Булган аймаг, Могод сум, Баруун Мухдагийн дурсгалт газрын ерөнхий байдал

Судлаач З. Батсайхан “Хүннү булшнууд ... уулын хошуурсан өвдөг, хамар дээр байрлах ба нар ээх уулын урд энгэр бэл, хонь мал бэлчих, хотлох зайтай, урд талаараа гол нууртай газар хүн тавих ёсыг эрхэмлэдэг нь хойт нас, нөгөө ертөнцийн тухай ойлголт төсөөлөлтэй холбоотой” (2002: 30) хэмээн тэмдэглэжээ. Түүнээс гадна оршуулгын газар нь овгийн ариун дагшин газар болохын хувьд уул овоотой өндөрлөг газар байрлах бөгөөд ойр орчмын газар нутаг нь илхэн харагдахаар гол төлөв урагшаа задгай байдаг (Төрбат, 2004:22-23) бололтой. Баруун мухдагийн оршуулгын газар нь байрлал зүйн хувьд дээрх судлаачдын тэмдэглэсэнтэй ерөнхийдөө тохирч байна. Баруун



Зураг 2. Булган аймаг, Могод сум, Баруун Мухдаг. Дэвсгэр зураг

Мухдагийн баруун талд буюу Орхоны их хавцалын эх, тэр хавийн хөндий болон уулсаар дугуй, дөрвөлжин хүрээтэй хиргисүүрүүд нэлээд тааралдах ба ялангуяа Асгатын голын зүүн талын дэвцэг дээр дугуй болон дөрвөлжин хүрээтэй хиргисүүр, өргөргийн дагуу цувруулан өрсөн зэл чулуу гэх мэт сонирхолтой байгууламжууд цөөнгүй байдаг. Үүнээс үзэхэд энэ нутагт эрт үеэс хүн суурьшиж амьдарч байсан бололтой бөгөөд өнөө ч бүлэг дурсгалаас холгүй айл нутаглаж байгаа нь хүннү нар нас барагсдаа хүн суурьших нөхцөл бүрдсэн газрын орчимд нутаглуулдаг байсан бололтой. Хүннүгийн зуу ба түүнээс дээш булштай томоохон оршуулгын газрыг өнгөцхөн харахад дотоод зохион байгуулалтын мэдэгдэхүйц ялгаа ажиглагдахгүй боловч тэрхүү эмх цэгцгүй мэт орших булшнуудаас зарим тохиолдолд хэсэг бүлэг булш ялгаран анхаарал татдаг нь Хүннү булштай газар элбэг тохиолддог нэгэн онцлог юм. Тухайлбал, Дэлгэрхаан уулын Энгэрийн бууц, Эгийн голын Бурхан толгой, Дуулга уул, Тамирын улаан хошууны Бурхан толгой, Солби уул зэрэг газарт дээрх зохион байгуулалт ажиглагддаг (Батсайхан, 2002: 28).


Баруун Мухдагийн оршуулгын газар ч тод ялгарахуйц хэдэн бүлэг булшнуудаас бүрдэнэ. Энд орших Хүннү булшнууд нь цагираг хэлбэртэй, дунджаар 3-16м голчтой, өөрөөр хэлбэл монгол оронд голлон тохиолдох хэв шинжийн булш боловч нэг онцлог нь зарим том цагираг хүрээтэй булшнууд нь урд зүгийг чиглэсэн үүдэвчтэй байгаа нь сонирхолтой байна. Уг дурсгалт газарт нийтдээ 257 булш байх ба үүдэвчтэй, цагираг хэлбэртэй, том 36, үүдэвчтэй, дөрвөлжин хэлбэртэй 1, он цагийг тодорхойлох боломжгүй 1 булш байна.

Эдгээр булшнуудыг дотоод байр зүйгээр нь болзолт байдлаар 4 бүлэг болгон хувааж үзэхэд А, В, С бүлэг тус бүрд 11-15 том булш байлаа (Зураг 2). Гэхдээ үүнийг дараа дараагийн судалгаагаар нарийвчлан тогтоох шаардлагатай юм. Энэхүү газарт 2007 онд 5 жижиг булш малтан судлахад 1

булшнаас нь ямар нэгэн оршуулгын зан үйл илрээгүй болно.

Булган аймгийн Могод сумын нутаг Баруун Мухдагт малтан судалсан булшнууд

101-р булш. Газарзүйн солбицол N0336663, E5382284. Оршуулгын газрын төв хэсэгт баруун захдуу орших 5м голч бүхий цагираг хэлбэрийн булш. Хүрээ цагирагны өргөн 100-200 см өргөн, зүүн хойд хэсэгтээ дараас чулуу цөөтэй. Булшны гадаад байгууламжийг цэвэрлэж дууссаны дараа төв хэсэгт малтлагыг үргэлжлүүлэхэд 50см гүнд уртрагийн дагуу байрласан 240x140см хэмжээтэй хүрвэртэр өнгийн булшны нүхний толбо илрэв.




Зураг 3. Булган аймаг, Могод сум, Баруун Мухдаг. 101-р булш

Булшны нүхний толбоны баруун захаар хэсэг чулуутай байв. Нүхийг дагуулан малтах явцад шороо чулуу холилдон гарсаар 200см гүнд оршуулга илрэв. Хүний хоёр хөл (дунд чөмөг, шилбэ) болон зүүн гар (бугалга, шуу) анатомын байрлалаараа боловч бусад ясыг хутган үймүүлжээ. Зүүн мөр, бугуй болон өвдөгний тус газар нумын гичир ба бариулын наалт, жижиг төмөр хутга анхны тавилтаараа байсан бол нүхний хойд хэсэгт хар өнгийн ваарны хагархай, хэлбэр дүрсгүй төмрийн хэсэг, богийн цөөн хэдэн яс гарав.

Нас барагчийг модон хашлага (эсвэл авс) дотор тавьж хөл тал болон зүүн талаар нь чулуу босгон шахжээ. Эд өлгийн зүйлээс үзвэл эрэгтэй хүн бололтой. Толгойн яс байхгүй, зарим нэгэн анатомын байрлалаар байгаа ясыг үзвэл толгойг нь чанх хойд зүгт хандуулан оршуулжээ. Нүхний гүн 210см, өргөн 80см, урт нь 220см (Зураг 3)

143-р булш. Газар зүйн солбицол N033656, E5382337. Оршуулгын газрын баруун хойд захдуу орших 6 х 8м голчтой цагираг хэлбэрийн булш. Хүрээ цагирагны



Зураг 4. Булган аймаг, Могод сум, Баруун Мухдаг 143-р булш
1 – Ваар, 2,5 - Бүсний чимэглэл, 3 - Сувс, 4 - Ясан савх

өргөн 200-300см. Булшны гадаад байгууламжийг цэвэрлэж малтлагыг үргэлжлүүлэхэд орчин үеийн өнгөн хөрснөөс доош 50см гүнд уртрагийн дагуу байрласан 300 х180см орчим булшны нүхний толбо илэрсэн бөгөөд уг толбоны захаар чигжээс чулуу мэт өрлөг гарлаа. Толбыг дагуулан цааш малтахад маш нягт хатуу тослог хар шавраар булшны нүхийг дүүргэсэн байлаа. Малтлагыг үрэлжлүүлэн

230см гүн болоход жигд зулж өрсөн хавтгай чулуунууд анхны байдлаараа мэт байрлалтай гарсан ба түүнийг аван доош цэвэрлэхэд нүхний төв хэсгээс хүний гавал болон хавирга зэрэг яс, дараагийн үеийн цэвэрлэгээгээр хүний бусад яс энд тэндээс олдож байлаа. Энэхүү үеийн доор ямар нэгэн




Зураг 5. Булган аймаг, Могод сум, Баруун Мухдагийн 143-р булшны олдворууд
 1,2,3 – Булшны дотоод зохион байгуулалт, 4,8 – Бүсний чимэглэл, 5 – Ваар, 6 – Ясан савх,
 7 – Хүрэл толины хагархай

зохион байгуулалтгүй нэг үе сул чулуу гарсны хойно оршуулгын чулуун хашлага илрэв.

Хашлагыг хавтгай чулуу босгон өрж хийсэн бөгөөд хойд хэсэгт нь тахилгын хүнс тавих тусгай зай гаргажээ. Уг тахилгын хэсэгт торх маягийн өвөрмөц хэлбэртэй бүтэн ваар, түүний зэрэгцээ вааран тогоо тавьсан байх бөгөөд дотор нь богийн үргэлжээрээ 12ш сээр нуруу хийжээ. толгойг хошууг нь баруун зүг харуулан тавьснаас гадна бүдүүн ямааны толгой болон бод, богийн хавирга, шилбэний яс зэргийг тавьжээ. Хүний ясыг хашлага дотор хутгаж орхисон бөгөөд цэвэрлэх явцад хос ясан савх, гоёмсог хээтэй хавтгай ясан эдлэлүүд, цагаан хүрэл толины хагархай зэрэг олдсон ба бүгд тонох үед зөөгдөн хөдөлжээ. Хашлаганы дотор хусны үйс дэвссэн ул мөр зарим газарт хадгалагдан үлджээ. Хүйс тодорхойгүй. Булшны гүн 270см, өргөн 130см болов (Зураг 4, б).

144-р булш. Оршуулгын газрын баруун хойд захдуу, 143-р булшны урд хэсэгт залгаа байрлах 2 x 3м голчтой цагираг хэлбэрийн булш. Уг жижиг байгууламжийг 144-р булш гэж тэмдэглээд 143-р булштай ямар нэгэн холбоотой эсэхийг тодорхойлох зорилгоор 1м гүн хүртэл малтаж үзсэн боловч ямар нэг нүхний толбо болон мал амьтны яс гарахгүй байгалийн хөрс үргэлжилсээр байсан тул малтлагыг зогсоов

216-р булш: Газар зүйн солбицол N0336845, E5382352. Талбайн хойд захдуу орших 3м орчим голчтой зууван цагираг хэлбэрийн жижиг булш. Гадаад байгууламжийг цэвэрлэх явцад наамал хээтэй ваарны хагархай хэсгүүд олдож байлаа. Малталтыг төв хэсэгт үргэлжлүүлэн явуулахад өнгөн хөрснөөс доош 40см гүнд уртрагийн дагуу, ялимгүй зүүн хойшоо чиглэсэн байрлалтай хашлага маягийн хэдэн чулуутай бор өнгөтэй нүхний толбо илрэв. Дараагийн үеийн малтлагаар 60см гүнд оршуулга байсан ул мөр илэрсэн боловч маш ихээр тоногдож зөвхөн хүн малын хэсэг яс үлдсэн байлаа. Нүхний хойд хэсэгт эвэртэй



Зураг 6. Булган аймаг, Могод сум, Баруун Мухдаг. 216-р булш. 1 – Булшны зохион байгуулалт, 2- Ваарны хагархай

ямааны толгой, эрүү болон цөөн хэдэн ваарны хагархайнаас өөр зүйл байсангүй. Нүхний гүн 60см, өргөн 100см, урт 200см болов. Нас барагчийн хүйсийг тодорхойлох боломжгүй байв (Зураг 6).


Ваартай оршуулга: 2006 онд солбицлыг тогтоох үед өгсөн дугаар харамсалтай нь тодорхой бус байгаа тул дахин солбицлыг тогтоох шаардлагатай юм. Талбайн төв хэсэгт байх үүдэвч бүхий том булшны баруун талд орших 400см орчим голчтой цөөвтөр чулуу бүхий цагариг хэлбэрийн булш. Гадаад байгууламжийг цэвэрлэсний дараа төв хэсгийг үргэлжлүүлэн малтахад 60см гүнд 130см орчим голчтой дугуй хэлбэрийн нүхний толбо илрэв. Толбыг дагуулан үе үеэр малтахад 150см гүнээс вааранд тавьсан хүүхдийн оршуулга илэрлээ. Ойролцоогоор 100см өндөр, нарийн амсартай том ваарны нэг талыг босоогоор нь цэвэрхэн зүсч аваад хэвтүүлэн тавьж хүүхдийг оршуулсан байсан нь тоногдож хүүхдийн яс анатомын байрлалаа алдаж зарим яс нь ялзран үгүй болжээ. Уг оршуулганд бүтэн адууны

Баруун Мухдаг дахь хүннүгийн булшнуудын гадаад зохион байгуулалт

Баруун Мухдагийн жирийн иргэдийн булшнууд нь харилцан адилгүй. Эдгээр булшнуудыг дотоод байр зүйгээр нь болзолт байдлаар 4 бүлэг болгон хувааж үзэхэд А бүлэгт 60 орчим, В бүлэгт 90 орчим, С бүлэгт 40 орчим, D бүлэгт 9, нийт 200 орчим жирийн иргэдийн булш байна. Булшнууд хоорондоо тодорхой хэмжээний зайтай газарт бүлгээрээ бөөгнөрсөн байдалтай оршино. Энэ нь тохиолдлын хэрэг бус бөгөөд он цаг, овог гэр бүл, нийгмийн байр суурийг элэрхийлсэн байж болох талтай.

2007 онд оршуулгын газрын баруун захад В бүлгээс 101, 143, 144, С бүлгээс 216 гэсэн булшнуудыг сонгон малтан судалсан бөгөөд цагираг хэлбэртэй, дунджаар 5-10м голчтой, 20-40см өндөр голдоо чулуун дараас цөөнтэй байна.

Баруун Мухдагийн үүдэвчтэй том булшнууд нь 60-80см өндөр, цагираг хэлбэрийн дараас чулуутай, цагаргийн өргөн 250-350 см бөгөөд гол хэсэгт өнгөн хөрсөн дээр чулуугүй, үүдэвчний хэмжээ харилцан адилгүй ажээ. Эдгээр булшнуудыг анх үйлдэхдээ л цагариг хэлбэртэйгээр үйлдсэн байх магадлалтай (Бат-Эрдэнэ, 2013: 238) гэж үзэж байна. Хүннү булш судлаач Ю.Д.Талько-Грынцевич хүннүгийн язгууртны булшийг дөрвөн өнцөгт дөрвөлжин хэлбэртэй, жирийн иргэдийн булшийг дугуй болон тодорхой бус хэлбэртэй (Талько-Грынцевич,1899:63,73) гэж үзсэн бол П.Б.Коновалов анхандаа дөрвөлжин хэлбэртэй байсан, тоногдсоноос болж голдоо чулуугүй цагариг хэлбэртэй болсон, мөн олон талтай, эсвэл дөрвөлжин (Коновалов,1980:19) гэх мэтээр тодорхойлсон байдаг. Гэхдээ хүннү булшийг цагариг хэлбэртэй гэж үзэх нь бодит байдалд илүү ойр юм. Учир нь жижиг булшийг тонох үед гадаад хэлбэр эвдэрч тодорхойгүй болдог бол том булш талбай ихтэй учраас гадаад байгууламж төдийлөн эвдрээгүй байдаг (Баруун Монгол төсөл, 2007:48), ялангуяа 10м-ээс дээш голчтой том булшин



Зураг 7. Булган аймаг, Могод сум, Баруун Мухдаг. Ваартай оршуулга

толгой, ямааны толгой, бодын эрүү дагалдуулан тавьснаас гадна ваарны дотор олон богийн шагай болон цагариг маягийн төмөр эдлэл зэргийг тавьсан байлаа. Булшны гүн 150см, 150 х 120см голчтой, зуван дугуй хэлбэртэй байв. Хүүхдийн нас тодорхойгүй боловч 10-аас доош насны хүүхдийнх бололтой (Зураг 7, 8).



Зураг 8. Булган аймаг, Могод сум, Баруун Мухдаг. Ваартай оршуулга
1, 2 – Хүүхдийг вааранд хийж оршуулсан байдал, 3 – Нумын бариул болон гичирийн ясан наалт, 4 – Хүүхдийг хийж оршуулсан том ваар

дээр анхдагч хэлбэр илүү тод сайн хадгалагдан үлдсэн байдгаас харахад Баруун мухдагийн язгууртны гэмээр том булшнуудыг анх үйлдэхдээ цагариг хэлбэртэй, үүдэвтэй үйлдсэн байж болно.

Хүннүгийн язгууртны оршуулгын газар одоогоор 10 олдоод байгаа нь Монгол улсын Төв, Архангай, Хэнтий, Ховд аймгийн нутагт, ОХУ-ын Буриадын Ильмийн ам, Царам, Тувагийн Бай-Даг- II зэрэг газарт байна.

Тодруулбал:

- Төв Монголд 4 оршуулгын газар /Ноён уул, Бэлх, Гол мод – I,II/
- Өвөр Байгалд 2 /Ильмийн ам, Царам/
- Дорнод Монголд /Дуурилаг нарс, Бор булаг/
- Баруун Монголд /Тахилтын хотгор, Бай-Даг- II/

Эдгээр оршуулгын газрын бөөгнөрөл, булшны тоог авч үзвэл Монгол улсад хамгийн их байна. Харин өмнөд Монголоос хүннүгийн язгууртны оршуулгын газар олноогүй нь нэг талаар Хүннү гүрний улс төр, эдийн засаг, соёлын гол төв нь өнөөгийн

Монгол нутаг байсныг харуулж байна (Ерөөл-Эрдэнэ, 2010:26). Монгол нутагт нийт 1500 орчим булштай 7 газрыг илрүүлэн олж тэдгээрээс язгууртны 20 гаруй, дагуул булш болон тахилгын байгууламж 111-г тус тус малтан судалжээ (Ерөөл-Эрдэнэ, 2010:18).

Өгүүлэн буй Баруун Мухдагийн хүннү булшны дурсгал өнөөгийн төв Монголын нутагт байрлах ба энэхүү бүс нутагт язгууртны булш хамгийн их байгаа нь уг бүс нутаг Хүннүгийн язгууртны гол төв хэсэг байсныг харуулж байна. Уг дурсгал нь нэг талаас Баруун Мухдагийн оршуулгыг үлдээгчид зориудаарс бусдаас өвөрмөц цагираг хэлбэртэй, үүдэвтэй оршуулгын зан үйлийг үйлдсэн байж болох, нөгөөтэйгүүр тухайн бүс нутгийн хүмүүсийн онцлогтой шууд хамааралтайг харуулж болох юм.

Аливаа оршуулгын газарт булш байгуулах гол материал болох чулуу олборлох хад асга бүхий уул ойр орчимд байх нь бас нэг чухал нөхцөл болдог (Ерөөл-Эрдэнэ, 2004:83). Баруун Мухдагийн

ойролцоох уулс нь чулуу ихтэй, түүгээр барахгүй булш байгуулахад ашигласан чулууг арын Асга уулын ойр орчмоос олборлож байсан нь тодорхой харагддаг.

Баруун Мухдагийн хүннү булшнуудын оршуулгын зан үйл

Баруун Мухдагийн булшнуудаас жижиг 5 булш малтан судлахад ерөнхий зохион байгуулалт, оршуулгын зан үйлийн хувьд бусад газрын хүннү булштай адилхан байсан боловч булшны нүх харьцангуй жижиг, мөн булшны нүхийг тослог, хатуу хар шавраар дүүргэсэн ялгаа ажиглагдлаа. Хүннүгийн язгууртны булшны байрлал зүй, дотоод зохион байгуулалтыг судлаад Ч.Ерөөл-Эрдэнэ язгууртны булшийг элсэрхэг хөрстэй, гүн хийдэг нь хожим тоногдохоос сэргийлсэн арга (Ерөөл-Эрдэнэ, 2004: 83) гэж үзсэн байдаг. Үүнтэй адил Баруун Мухдагийн оршуулгын газар булшны нүхийг тослог, хатуу хар шавраар дүүргэсэн байгаа нь тухайн нутгийн хүн ам нас барагчийнхаа булшийг хожим тоногдохоос сэргийлсэн хамгаалалтын нэг хэлбэр байсан байж болох юм.

Эндэх булшны нүхний гүн дунджаар 200-300см, модон авс эсвэл чулуун хашлага үйлдэн оршуулсан байсан ба энэ нь хүннү булшинд тохиолдох нийтлэг шинж юм. Булшны дотоод зохион байгуулалтыг булш тус бүрээр авч үзвэл, 101-р булшинд модон хашлага эсвэл авс маягийн зүйлд хүнээ тавьсан байсан бол 143, 216-р булшнуудад хүнээ жигд өрсөн хавтгай чулуун тагтай, чулуун авсанд оршуулсан байсан нь тухайн үеийн энэ нутгийн оршин суугчдын оршуулгын зан үйлийн нэг онцлог бололтой. Түүнчлэн вааранд хийсэн хүүхдийн оршуулга илэрсэн нь маш ховор, сонирхолтой тохиолдол болох юм. Хүннүгийн үеийн хүүхдийн оршуулгыг авч үзвэл, Дэрестуйн кутлугт хүүхдийн 19 оршуулга илэрсний 7 нь чулуун хашлаганд, 2 нь модон авсанд, бусад нь газар оршуулагдсан (Миняев, 1998:76), Ильмийн амны 19, 28-р булшнуудад эмэгтэй хүнийг

хүүхдийн хамт (Галько-Грынцевич, 1899:63,73) оршуулсаж байжээ. Харин Монгол нутагт малтсан хүннү булшны хувьд, Эгийн голд хийгдсэн судалгаагаар нийт 20 хүүхдийн оршуулга илэрсний 8 нь насанд хүрэгчдийн булштай хамт, 12 нь тусгайлан үйлдсэн булш байжээ. Хүүхдийн оршуулгыг 1-рт: дагуул булш буюу тахилгын зан үйлийн дагуу үйлдсэн булш, 2-рт: бие даасан шинжтэй, насанд хүрэгчдийн адил зан үйлээр оршуулсан булш гэсэн 2 хэлбэртэй гэж үзжээ (Төрбат, 2004:53-56).

Баруун Мухдагт малтан судалсан булшин дунд хүүхдийг тусгайлан вааранд хийж оршуулсан тохиолдол илэрсэн бөгөөд оршуулгын хэлбэр, булшны дотоод зохион байгуулалт зэргээс харахад хүүхэд оршуулах хэд хэдэн зан үйлийн хэлбэр байсан байж болохоор байна. Энэ зан үйл нь хүннүгийн үед хүүхдийг насанд хүрэгчдээс өөрөөр оршуулж байсныг гэрчилж байна. Иволгийн суурингийн газарт нийт 49 хүүхдийн оршуулга илэрсэн ба 1-3 насны хүүхдийг шавар вааранд, өсвөр насны хүүхдийг том хүний адил оршуулж ваарны хагархайгаар даруулсан тохиолдол илэрч байжээ (Давыдова, 1995:24-25). Ваар саванд хийж оршуулсан оршуулга нь нярай буюу бага насны хүүхэд байгаа нь тухайн үеийн нүүдэлчдийн хүүхдэд хандах хандлага, хүүхдийн тухай тэдний ертөнцийг үзэх үзлийг тайлбарлах нэгэн сэжүүр болж болох талтай. Ийм оршуулгын хэлбэр нь нас барагч хүүхдийг эхийн хэвлий болон сав, умайндаа амар амгалан нойрсож байгаа гэсэн утгыг илэрхийлдэг байж болох юм (Бямба-Очир, 2010:37). Баруун Мухдагийн хүүхдийн оршуулга нь хүүхдийг вааранд хийн насанд хүрэгчдийн адилаар тусгайлан оршуулсан байгаа нь тухайн хүүхэд жам ёсоороо нас барсныг илэрхийлэхээс гадна тэр үеийн хүмүүсийн ертөнцийг үзэх үзэл, өмнөх амьдрал, хойт нас, сүсэг бишрэл, нас барсан шалтгаан, нийгмийн байр суурь, угсаа гарвал зэрэгтэй салшгүй холбоотойг харуулж байгаа юм.

ДУГНЭЛТ

Баруун Мухдагийн хүннү булшнууд нь өнөөгийн төв Монголын нутагт байрлах ба энэхүү бүс нутагт язгууртны булшны тархац хамгийн их байгаа нь уг нутаг Хүннүгийн гол төв хэсэг байсныг харуулж байна. Уг оршуулгын газар байрлалын хувьд наран ээвэр уулын энгэр газар, гол уснаас төдийлөн холгүй байгаа нь хүннүгийн булшны дурсгалын ерөнхий шинжтэй адил байна. Булшнууд хоорондоо тодорхой хэмжээний зайтай газарт бүлгээрээ бөөгнөрсөн байдалтай орших ба дотоод байр зүйгээр нь болзолт байдлаар А, В, С, D гэсэн 4 бүлэг болгон хувааж болохоор байгаа нь тохиолдлын хэрэг бус, он цаг, овог гэр бүл, нийгмийн байр суурийг илэрхийлсэн байж болох талтай.

Энэхүү газарт буй булшнууд нь хүннүгийн булшны ерөнхий хэв шинжийг хадгалж байгаа хэдий ч зарим өвөрмөц онцлогууд ажиглагдаж байна. Тухайлбал, жирийн иргэдийн булш, болон язгууртны булш хамтдаа нэг дор цогцолбор шинжтэйгээр оршиж байгаа, язгууртны гэмээр том булшнууд нь үүдэвчтэй мөртлөө цагариг хэлбэртэй байгаа зэрэг нь нэн сонирхолтой байна. Язгууртны гэмээр том булшнуудыг анх үйлдэхдээ л цагираг хэлбэртэй, үүдэвчтэй үйлдсэн байх

үндэслэлтэй бөгөөд оршуулгыг үлдээгчид ийнхүү бусдаас өвөрмөцөөр оршуулгын зан үйлийг үйлдсэн нь тухайн бүс нутгийн хүмүүсийн онцлогтой шууд хамааралтайг харуулж болох юм.

Мөн Монгол болон Өвөр Байгалийн нутагт ховор тохиолддог, нүүдэлчдийн дунд төдийлөн түгээмэл тохиолддоггүй зан үйл болох хүүхдийг тусгайлан вааранд хийн оршуулсан нь тухайн бүс нутгийн онцлог байж болох бөгөөд оршуулгын хэлбэр, булшны дотоод зохион байгуулалт зэргээс харахад хүннүгийн үед хүүхдийг насанд хүрэгчдээс өөрөөр оршуулж байсныг илэрхийлж байна.

Баруун Мухдагт малтан судалсан цөөн хэдэн булшны хэрэглэгдхүүнээр уг дурсгалын талаар нэгдсэн дүгнэлт хийх хараахан боломжгүй бөгөөд дараа дараагийн судалгааны ажлаар улам лавшруулан судалж бүрэн дүгнэлт хийх боломжтой болно гэдгийг цохон тэмдэглэж байна. Энэхүү дурсгалыг цогцоор нь судлан шинжилж эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулбал уг бүс нутгийн нүүдэлчдийн нийгмийн байгуулал, соёлын болон угсаатны холбоо хамаадал, бусад овог аймгуудын харилцаа зэргийг тодруулахад бага ч гэсэн хувь нэмэр болох сонирхолтой үр дүн гарах боломжтой юм.

ТАЛАРХАЛ

Энэхүү бүлэг дурсгалыг Шинжлэх Ухаан Технологийн сангийн санхүүжилтээр гүйцэтгэсэн “Баруун Монгол: Археологи, Антропологи” эрдэм шинжилгээний төслийн хүрээнд нээн илрүүлж малтлага судалгааг явуулсан болно. Уг дурсгалын малтлага судалгааны үр дүнг шинжлэх ухааны эргэлтэнд оруулах боломж олгосон МУИС-ийн Антропологи-Археологийн тэнхимийн багш доктор, дэд профессор З.Батсайханд талархал илэрхийлье.

НОМ ЗҮЙ

Батсайхан З., 2002. Хүннү. Улаанбаатар

Бат-Эрдэнэ С., 2013. Хүннүгийн өвөрмөц нэгэн дурсгалын тухай. - *Древние культуры Монголии и Байкальской Сибири*. Сборник докладов. IV международная научная конференция. Чита, с. 230-239

Баруун Монгол төсөл, 2007. Тамирын улаан хошуу, Баруун Мухдагийн булш. - МУИС, НШУС, Археологи-Антропологийн тэнхим. Улаанбаатар

Бямба-Очир Ц. 2010. Монголын эртний нүүдэлчдийн хүүхдийн оршуулга. - Магистрын зэрэг горилсон бүтээл. МУИС, НШУС, Археологи-Антропологийн тэнхим. Улаанбаатар, 33-

- Давыдова А.В.*, 1995. Иволгинский археологический комплекс т.2. - *Иволгинский могильник*. Санкт-Петербург, с. 24-25
- Ерөөл-Эрдэнэ Ч.*, 2004. Гол модны хүннү булшны судалгааны зарим үр дүн. - *Studia Archaeologica*, Tomus XXII. Fasc.23. Улаанбаатар, х. 83
- Ерөөл-Эрдэнэ Ч.*, 2010. *Хүннүгийн язгууртны оршуулгын дурсгалын судалгаа*. Докторын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар Их Сургууль, НУФ.Улаанбаатар, х. 10-18
- Коновалов П.Б.*, 1980. Погребальные сооружения хунну. ИКВА. Новосибирск.
- Миняев С.С.*, 1998. Дырестуйские памятники. - Археологические памятники Сюнну.-Вып.3. Санкт-Петербург. с. 76-77
- Талько-Грынцевич Ю.*, 1899. Суджинское доисторическое кладбище в Ильмовой пади М., Т. XII. 63. с. 73
- Төрбат Ц.*, 2004. *Хүннүгийн жирийн иргэдийн булш*. Улаанбаатар

SUMMARY

S.BAT-ERDENE

XIONGNU BURIALS AT BARUUN MUHDAG SITE, MOGOD SOUM, BULGAN AIMAG

The aim of this article is to introduce a new complex burial site from Xiongnu period found at Baruun Muhdag site in Bulgan Province. Besides common burials, elite burials of uncommon shape with circular feature and dromo were identified at the site as well. Furthermore, one of five burials we excavated had a burial of a baby buried in a jar.